



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 03 өдөр

Дугаар А/02

Ховд

Газар эзэмших зөвшөөрөл олгох тухай

Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2 дахь заалт, 33 дугаар зүйлийн 33.1.1 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2010 оны 267 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Жаргалант сумын Цамбагарав баг Ану хатан 1 дүгээр гудамжны 112 а тоотод байрлах 4358 метр квадрат газрыг “Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв”, -д албан хэрэгцээний зориулалтаар 15 жилийн хугацаагаар эзэмшүүлсүгэй.

2. Газар эзэмших эрх нь баталгаажсан аж ахуй нэгжтэй газар эзэмшүүлэх гэрээ байгуулж, газар эзэмших эрхийн гэрчилгээ олгон, газрын төлбөрийг хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэн гэрээний биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Э.Дөлбадрал/-т даалгасугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2020 оны А/365 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

8400 01 0005

D/Zah-A/02-Bo